

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**АУДИТЫН КОД: ХЭА-2020/02/-ГА**

Хэрлэн сум 2020 он



**Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх  
аудитор Ч.Эрдэнэбаатар**

Утас: 70562112 Цахим хаяг: [erdenebaatararch@audit.gov.mn](mailto:erdenebaatararch@audit.gov.mn)

**Аудитын менежер Д.Оюунтуяа**

Утас: 70562147 Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

**Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг**

Утас: 70562147 Цахим хаяг: [erdenebilegd@audit.gov.mn](mailto:erdenebilegd@audit.gov.mn)

**Аудитор Ц.Энхтүвшин**

Утас: 70562147 Цахим хаяг: [enkhtuvshints@audit.gov.mn](mailto:enkhtuvshints@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

АГУУЛГА

Хүснэгтийн товьёг.....Error! Bookmark not defined.  
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....5

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН БАЙНА.....8**  
**А.1. Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч сонгох сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлтийг сонгуулийн ерөнхий хороо төлөвлөсөн байна.....8**  
**А.2 Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулах зардлын төсвийг холбогдох тушаалын дагуу хуваарилсан байна. ....9**

**БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН 1.0 ХУВИЙГ АРВИЛАН ХЭМНЭСЭН БАЙНА.....10**  
**Б.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлтэй зарцуулсан байна.....10**  
**Б.2 Нийт 564.1 мянган төгрөгийн зардлыг холбогдох зөвлөмжийн дагуу тайлагнаагүй байна.....14**  
**Б.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна. ....16**

Холбогдох байгууллагын санал: .....18  
Саналд өгсөн тайлбар:.....19  
ДҮГНЭЛТ: 20  
ЗӨВЛӨМЖ: .....21

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс

### Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<b>Дүрслэл 1</b>	Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны сонгуулийг зохион байгуулах сонгуулын төсвийн бүтэц	10
<b>Дүрслэл 2</b>	Сонгуулийн төсвийн хэмнэлт, хэтрэлт	12
<b>Дүрслэл 3</b>	Аудитаар илрүүлсэн зөрчилд сумдын СХ-ны эзлэх хувь	15

### Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<b>Хавсралт 1</b>	Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах аймаг, сумын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл	21
<b>Хавсралт 2</b>	Хэнтий аймгийн аймаг, сумын сонгуулийн хорооны 2020 оны аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулсан зардлын тайлан	22
<b>Хавсралт 3</b>	Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан аймаг, сумын сонгуулийн хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа	23

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан “Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.</p>
<b>Аудитын зорилт</b>	<p>“Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн Сонгуулийн хороо болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>➤ <i>Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;</i></li><li>➤ <i>Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;</i></li></ul>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	<p>Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын газар зэрэг байгууллагуудыг хамруулан 2020 оны орон нутгийн ИТХ-ын сонгуулийн зардалд аудит хийв.</p>
<b>Аудитын хязгаарлалт</b>	<p>.....</p>
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудаас асуулга лавлагаа, тодруулга авах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, аудитор Ц.Энхтүвшин хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 06-ний хооронд хийж гүйцэтгэн, аудитыг гүйцэтгэх ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 09-өөс 11 дүгээр сарын 24-ны өдрүүдэд, тайлагналын үе шатыг 2020 ны 11 дүгээр сарын 27-ны дотор дуусган, аудитын тайлан, судалгааг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2020 оны 11 дүгээр сарын 27-нд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн Сонгуулийн хороо, аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

**Хүндрэл  
бэрхшээл**

.....

**АУДИТЫН ДҮН: *ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОХ СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.***

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна.

Энэ хуулийн дагуу зохион байгуулагдах 2020 оны ээлжит аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгуулийг аймгийн хэмжээнд зохион байгуулах сонгуулийн хороог Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 47 тоот тогтоолоор аймгийн Сонгуулийн хороог Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүдтэй нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Хэнтий аймгийн 2020 оны ээлжит аймаг, сумын сонгуулийг 93 хэсгийн хороодтой зохион байгуулж тэдгээрт ажиллах 917 төрийн албан хаагч ажилтан томилогдон, нэмэлтээр иргэний бүртгэл, цагдаа, эрүүл мэндийн 279 ажилтан нийт 1196 ажилтан ажилласан байна.

Аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчийг сонгох 2020 оны ээлжит сонгуульд Хэнтий аймагт санал өгөх сонгогчийн нэрийн жагсаалтад 49621 сонгогч бүртгэлтэй байгаагаас санал хураалтад нийт 31154 сонгогч буюу иргэдийн 62,78 хувь нь саналаа өгсөн байна.

СЕХ-ноос Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд 53373 ширхэг саналын хуудас олгосноос 31977 ширхэг буюу 59,9 хувь нь санал хураалтад зарцуулагдаж, 1014 ширхэг саналын хуудсыг хүчингүй болж, 21396 ширхэг саналын хуудас зарцуулагдаагүй үлдсэн байна.

Хэнтий аймгийн аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчийг сонгох 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн ерөнхий хорооноос Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд 475.3 сая төгрөгийг хуваарилан баталжээ.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Хэнтий аймагт хуваарилсан санхүүжилтээс аймгийн Сонгуулийн хороонд 48,5 сая төгрөгийг, сумын хэсгийн хороодод 426,8 сая төгрөг хуваарилж, гүйцэтгэлээр аймгийн сонгуулийн хороо 46,9 сая төгрөг, сумын сонгуулийн хороод 423,5 сая төгрөгийг зарцуулж, нийт дүнгээр 4,9 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг СЕХ-ны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Хэнтий аймгийн аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас сонгогчийн бээлий 40666 ширхэгийг хуваарилснаас 2400 ширхэг, сонгуулийн ажилтны бээлий 2751 ширхэгийг хуваарилснаас 300 ширхэг тус тус үлджээ. Мөн

спиртэн суурьтай гар ариутгагч /санитол/ 500 ширхэг хуваарилагдсанаас 99 ширхэг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Улсын Бүртгэлийн Ерөнхий газраас Хэнтий аймгийн УБХэлтэст сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, цахим хуудаст байрлуулах, сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах, санал авах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэж хүргүүлэх, татан авах болон шуурхай багийн зардал, албан хаагчийн сургалт зохион байгуулах, томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардалд нийт 62,0 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 62,0 сая төгрөгийг зарцуулж 0,1 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

## **БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫГ СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ТӨЛӨВЛӨЖ, БАТАЛСАН БАЙНА.**

### **А.1. Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч сонгох сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлтийг сонгуулийн ерөнхий хороо төлөвлөсөн байна.**

Монгол улсын Их Хурлаас шинээр баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай”, “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хуулиудыг үндэслэн 2020 оны ээлжит аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчийг сонгох сонгуулийг зохион байгуулах зардлыг Сонгуулийн Ерөнхий хороо төлөвлөн 2020 оны 08 дугаар сарын 26-ны 3/396 тоот албан бичгээр "Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар"-аар сонгуулийн хороодын зардлын санхүүжилтын 1 дүгээр хэсэг, 2020 оны 09 дүгээр сарын 14-ны 3/430 тоот албан бичгээр сонгуулийн хороодын зардлын санхүүжилтын 2 дугаар хэсэг, 2020 оны 09 дүгээр сарын 28-ны 3/450 тоот албан бичгээр сонгуулийн хорооны зардлын санхүүжилтын 3 дугаар хэсэг, 2020 оны 10 дугаар сарын 07-ны 3/465 тоот албан бичгээр сонгуулийн хорооны зардлын санхүүжилтын 4 дүгээр хэсэг, Сонгуулийн Ерөнхий хорооны 2020 оны 10 дугаар сарын 21-ны 3/477 тоот албан бичгээр сонгуулийн хорооны зардлын санхүүжилтын 5 дугаар хэсгийг төлөвлөж ирүүлсэн байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо "Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын" төлөвлөлтийг хийхдээ СЕХ-оос ирсэн тооцооллыг баримтлан аймгийн Сонгуулийн хороо 2020 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн №10 албан тоот, 2020 оны 09 дүгээр сарын 24-ны №18 албан тоот, 2020 оны 10 дугаар сарын 12-ны №33 албан тоотоор тус тус төсвийн зарцуулалтын талаар чиглэл өгсөн байна.

Мөн дахин сонгууль зохион байгуулагдсан Өмнөдэлгэр, Дэлгэрхаан сумдын Сонгуулийн хороонд 2020 он 10 дугаар сарын 21-ны №38 албан тоотоор нэмэлт санхүүжилтийг зарцуулах чиглэлийг хүргүүлжээ.




Хэнтий аймгийн хэмжээнд аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгуульд Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/34 тоот Захирамжаар улсын төсвөөс 475.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн ирүүлснийг дээрхи тооцооллыг мөрдөн аймаг, сумдын Сонгуулийн хорооны зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгуулийг зохион байгуулах "Туршилтын болон санал авах өдөр сонгуулийн дүн, мэдээ дамжуулах унааны зардал"-д аймгийн төв болон сумын төвд буй сонгуулийн хэсгүүдэд зардал хуваарилаагүй байхад аймгийн Сонгуулийн хорооны төсөвт 385.0 мянган төгрөг тусгасан байна.

## А.2 Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулах зардлын төсвийг холбогдох тушаалын дагуу хуваарилсан байна.

А.2.1. Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь аймаг, сумын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумын сонгуулийн хорооны санхүүжилтийг олгохдоо СЕХ-оос гаргасан чиглэл, тооцооллыг баримтлан төсвийг зардал тус бүрээр сумдад хуваарилан олгосон ба аудитаар тулган батагаажуулалт хийхэд сонгууль зохион байгуулахтай холбогдон гарсан журмыг баримтлан санхүүжүүлсэн байна.

Энэхүү журмыг баримтлан нийт 475,3 сая төгрөгөөс аймгийн Сонгуулийн хороонд 48,2 сая төгрөг, сумдын Сонгуулийн хороодод 426,8 сая төгрөгийг хуваарилсан байна. Үүнээс: Урамшуулал, хоолны зардалд 309,7 сая төгрөг буюу 65,2 хувь, томилолт, унаа, сургалт, сурталчилгааны зардалд 70,4 сая төгрөг буюу 14,8 хувь, үлдэх 95,2 сая төгрөг буюу 20,0 хувийг бусад зардлуудад хуваарилжээ.



Дүрслэл 1

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2020 оны 09 дүгээр сарын 02-ны А/1304 тоот "аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай" тушаалаар орон нутгийн сонгууль зохион байгуулах зардалд Хэнтий аймгийн УБХ-т 62.0 сая төгрөгийг бүртгэлийн ажилтнуудын урамшуулал, сургалт зохион байгуулах, техник хэрэгсэл тээвэрлэх, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэх тараах ажлыг хэрэгжүүлэхэд тусгасан байна.

Улсын Онцгой комиссоос аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль зохион байгуулахад зориулж 1 удаагийн бээлий 43417 ширхэг, гар ариутгагч санитол 500 ширхэгийг хуваарилан ирүүлсэн байна.

А.2.2. УБЕГ-ын даргын 2020 оны 09 сарын 02-ны өдрийн А/1304 дугаар тушаалаар Хэнтий аймгийн болон сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулах зардалд нийт 60,3 сая төгрөг батлагджээ.

Батлагдсан төсөвт УБХ-ийн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардалд 43,8 сая төгрөг, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд 4,2 сая төгрөг, сургалт зохион байгуулахад 9,1 сая төгрөг, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардалд 3,1 сая төгрөг тус, тус батлагдсан байна.

Сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлахдаа сонгуулийг 89 хэсгийн хороогоор зохион байгуулагдахаар тооцсон боловч аймгийн Сонгуулийн хороо хэсгийн хороодын тоог 93 байхаар баталсан байна.

Үүнээс шалтгаалан итгэмжлэгдсэн ажилтны тоо 4-өөр нэмэгдэж, тэдгээр ажилтны урамшуулал 1,7 сая нэмэгдэж, нийт төсөв 62,0 сая төгрөг болж өссөн байна.

**БҮЛЭГ 2. АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН 1.0 ХУВИЙГ АРВИЛАН ХЭМНЭСЭН БАЙНА.**

**Б.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлтэй зарцуулсан байна.**

Б.1.1. Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 2020 оны ээлжит сонгуулийн Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд нийт 475.3 сая төгрөгийн төсөвтэйгээр зохион байгуулахаар төлөвлөснөөс 470.4 сая төгрөгийг зарцуулан 4.8 сая төгрөгийг хэмнэж Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарцуулалтыг зардлын нэр төрөл тус бүрээр хянавал:

1. Аймгийн Сонгуулийн хороонд тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардалд 300.0 мянган төгрөгийг хуваарилснаас 193.6 мян.төг зарцуулагдаж 106.4 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

2. Сонгуулийн байгууллагын ажилтны үнэмлэх хэвлүүлэх зардалд зориулж аймгийн Сонгуулийн хороонд төсөвлөгдсөн 2640.0 мянган төгрөгөөс 2552.0 мянган төгрөгийг зарцуулж 88.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна

3. Орон нутгийн сонгуулт зохион байгуулах ажилтнуудын сургалтын зардалд нийт 4458.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 4392.1 мянган төгрөг зарцуулагдаж, 65.9 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

*Хэмнэгдсэн зардлын 0.7 мянган төгрөг нь аймгийн Сонгуулийн хорооноос, 65.2 мянган төгрөг нь сумын Сонгуулийн хороодод хуваарилагдсан төсвөөс хэмнэгджээ.*

4. Мэдээлэл технологийн багийн гишүүд ба даамлуудын сургалтын зардалд 12820.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 12506.4 мянган төгрөг зарцуулагдаж, 313.6 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

*Үүний 0.7 мянган төгрөг нь аймгийн Сонгуулийн хороо, 312.9 мянган төгрөг нь сумын Сонгуулийн хороодоос хэмнэгджээ.*

5. Сонгуулийн үйл ажиллагааны бичиг хэргийн зардалд 10940.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 10966.0 мянган төгрөг зарцуулагдаж, 26.0 мянган төгрөгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуужээ.

*Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвийг бүрэн зарцуулсан бол сумын Сонгуулийн хороодод хуваарилагдсан төсвийг 26.0 мянган төгрөг илүү зарцуулсан байна.*

6. Сонгуулийн үйл ажиллагааны шуудан холбооны зардалд 13000.0 мянган төгрөг төсөвлөгдсөнийг аймаг, сумын Сонгуулийн хороод бүрэн зарцуулсан байна.


7. Сонгуулийн үйл ажиллагааны унааны зардалд 49450.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 47933.1 мянган төгрөг зарцуулагдаж, 1516.9 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

*Аймгийн Сонгуулийн хороо нь 1750.0 мянган төгрөгөө бүрэн зарцуулсан бол сумын Сонгуулийн хороод 1516.9 мянган төгрөг хэмнэжээ.*

8. Санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардалд 20460.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 20386.7 мянган төгрөг зарцуулагдаж, 73.4 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

*Аймгийн Сонгуулийн хороо нь хуваарилагдсан төсвөө бүрэн зарцуулсан бол сумын Сонгуулийн хороод 73.4 мянган төгрөг хэмнэжээ.*

9. Сонгуулийн сурталчилгааны зардалд 8000.0 мянган төгрөг төсөвлөгдсөнийг аймгийн Сонгуулийн хороонд хуваарилаж, бүрэн зарцуулсан байна.



Дүрслэл 2

10. Санал тоолох ICP төхөөрөмжийг аймаг, сумын Сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх зардалд 21214.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 20903.1 мянган төгрөг зарцуулагдаж, 310.9 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

*Аймгийн Сонгуулийн хороо 328.0 мянган төгрөгийг зарцуулаагүй бол сумын Сонгуулийн хороод 17.1 мянган төгрөгийг илүү зарцуулагдсан байна.*

11. Мэдээлэлийн технологийн багийн зардалд 650.0 мянган төгрөг төсөвлөгдсөнийг бүрэн зарцуулжээ.

12. Автоматжуулсан системийг ажиллуулахад шаардлагатай эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардалд 3255.0 мянган төгрөг төсөвлөгдсөнийг сумын Сонгуулийн хороодод хуваарилж, 2847.6 мянган төгрөг зарцуулагдаж 407.4 мянган төгрөг хэмнэгджээ.

13. Саналын хуудас, сонгуулийн дүн тайлан хүлээлгэн өгөх зардалд 7404.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 7010.7 мянган төгрөг зарцуулагдаж, 393.3 мянган төгрөг хэмнэгджээ.

*Аймгийн Сонгуулийн хороо 357.7 мянган төгрөг, сумын Сонгуулийн хороод 35.7 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.*

14. Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дэмжуулах унааны зардалд 3630.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 3113.6 мянган төгрөг зарцуулагдаж, 516.4 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан 385.0 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Харин сумын Сонгуулийн хороодод хуваарилагдсан санхүүжилтээс 131.4 мянган төгрөг хэмнэгджээ.

15. Болзошгүй зардалд 7408.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 6320.8 мянган төгрөг зарцуулагдаж, 1087.2 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвөөс 283.9 мянган төгрөг, сумын Сонгуулийн хороодод хуваарилагдсан төсвөөс 803.3 мянган төгрөг тус тус хэмнэгджээ.


16. Аймаг, сумын сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардалд 270860.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 270790.0 мянган төгрөг зарцуулагдаж, 70.0 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан 5130.0 мянган төгрөгөөс 70 мянган төгрөг хэмнэгдэж сумын Сонгуулийн хороонд хуваарилагдсан санхүүжилтыг бүрэн зарцуулжээ.

17. Мэдээллийн технологийн багийн гишүүд, санал авах байрны даамлын урамшуулал хоолны зардалд 38810.0 мянган төгрөг төсөвлөгдсөн боловч 38860.0 мянган төгрөг буюу 50.0 мянган төгрөг илүү зарцуулагдсан байна.

Үүнийг аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан санхүүжилтийг 50.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан бол сумын Сонгуулийн хороодод хуваарилагдсан санхүүжилт бүрэн зарцуулагдсан байна.

Улсын Онцгой комиссоос Хэнтий аймагт хуваарилан ирүүлсэн 1 удаагийн 43417 бээлийнээс 40717 ширхэгийг зарцуулж 2700 үлдсэн, гар ариутгагч 500 ширхэг ирснээс 401 ширхэгийг зарцуулж 99 ширхэг тус тус үлдсэнийг аймгийн Сонгуулийн хорооноос аймгийн Онцгой байдлын газарт хүлээлгэн өгсөн байна.



Б.1.2. Аймгийн УБХ нь сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор нийт 62042.5 мянган төгрөг зарцуулж, 0.1 мянган төгрөг хэмнэжээ. Зардал тус бүрийг авч үзвэл:

1. УБХ-ийн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардалд 45528.8 мянган төгрөг зарцуулж, 0.1 мянган төгрөг хэмнэжээ.

2. Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардалд 4308.0 мянган төгрөг зарцуулж, 86.9 мянган төгрөг хэтэрсэн нь сонгогчдийн нэрийн баталгаажсан жагсаалт хүргэх зардалтай холбоотой байна.

3. Сургалт зохион байгуулахад 8534.3 мянган төгрөг зарцуулж, 659.5 мянган төгрөг хэмнэжээ.

4. Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардалд 3671.5 мянган төгрөг зарцуулж, 572.5 төгрөг хэтэрсэн нь санал авах өдөр Дархан суманд хурууны хээ таних төхөөрөмж эвдэрч шуурхай баг ажилласан, нэмэлт санал хураалтын техник хэрэгслийг хүргэсэн, хэсгийн хорооны тоо нэмэгдснээс сумын сонгуулийн хорооноос УБХ-т сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэлийг хүргэх зардал нэмэгдсэн зэрэг шалтгаантай холбоотой байна.

## **Б.2 Нийт 564.1 мянган төгрөгийн зардлыг холбогдох зөвлөмжийн дагуу тайлагнаагүй байна.**

Б.2.1. Орон нутгийн 2020 оны ээлжит сонгууль зориулж Сонгуулийн Ерөнхий хорооноос Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан санхүүжилтын бодитой тайлагнасан байдлыг үзвэл нийт төсвийн дийлэнх хэсгийг холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв тайлагнасан боловч зарим зардлыг төсөвлөснөөс өөр зүйлд зарцуулсан байна.

*Аймгийн хэмжээнд нийт 135.2 мянган төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн зарцуулж, 305.1 мянган төгрөгийн зардлыг үнэн зөв тайлагнаагүй, 123.8 мянган төгрөгийг төсөвлөгдөөгүй зардалд зарцуулсан байна.*

Аудитаар илэрсэн зөрчлийг тайлагнавал:

1. Аймгийн Сонгуулийн хороо мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулал, хоолны зардалд Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардлаас 50.0 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.


2. Галшар сумын Сонгуулийн хороо бичиг хэргийн зардалд санал авах байр бэлтгэх зардлаас 43.0 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан, мөн сургалтын зардлаас 134.9 мянган төгрөг, унааны зардлаас 170.2 мянган төгрөгийн зардлыг дутуу, саналын хуудас ИСР төхөөрөмж хүлээлгэн өгөх зардалд 105.1 мянган төгрөг, албан томилолтын зардалд 200.0 мянган төгрөгийг илүү тайлагнасан байна.

3. Баянхутаг сумын Сонгуулийн хороо санал авах байр бэлтгэх зардалд бичиг хэргийн зардлаас 0.4 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.

4. Өмнөдэлгэр сумын Сонгуулийн хороо нь автоматжуулсан системийн эрчим хүчний эх үүсвэр бэлтгэхэд хуваарилагдсан зардлыг хэтрүүлэн болзошгүй зардлаас 30.0 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.

5. Биндэр, Норовлин сумын Сонгуулийн хороо автоматжуулсан системийн эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас санал авах байр бэлтгэхэд 11.8 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.

6. Хэрлэн сумын Сонгуулийн хороо төсөв хуваарилагдаагүй сонгуулийн байгууллагын ажилтны сургалтын зардалд санал авах байрны даамлын сургалтын зардлаас 123.8 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.



Дүрслэл 3

*Ингэхдээ Өлзийт, Тахилгат тосгоны санал авах байрны даамлын нэг өдрийн томилолт 100 мянган төгрөг, унааны зардал 23.8 мянган төгрөгийг дутуу олгосон байна.*

Сонгуулийн зардлаас бэлтгэгдсэн нийт 48 нэр төрлийн 2165.8 мянган төгрөгийн эд материалыг бүртгэн сумын ЗДТГ болон холбогдох байгууллагад шилжүүлсэн байна.

Б.2.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой нийт 62042,6 мянган төгрөгийн 31 гүйлгээ сонгууль зохион байгуулах хугацаанд хийгдсэн байна.

Үүнээс тухайн арга хэмжээнд зайлшгүй шаардлагатай бус зарим хэмнэгдэх боломжтой зардлыг хэмнээгүй байна. Үүнд:

1. Суралтын зардалтай шууд холбоотой биш, харин байгууллагын техник хэрэгслийн бүрэн, бэлэн байдалтай холбоотой принтерийн залгуур 20 ширхэг, зөөврийн компьютерийн залгуур 30 ширхэг, уртасгагч 2 ширхэг, сүлжээний толгой 100 ширхэг, нийт 1399.3 мянган төгрөгийн эд зүйлс худалдан авсан нь байна.

2. Политехник коллежийн урлаг зааланд итгэмжлэгдсэн ажилтны сургалтыг зохион байгуулж, төлбөрт нь 120.0 төгрөг шилжүүлсэн байна.

Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлаас хэмнэгдсэн 659.5 мянган төгрөгөөс 86.9 мянган төгрөгийг сонгогчийн нэрийн жагсаалт хүргэх 572.5 мянган төгрөгийг сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл тээвэрлэх, шуурхай багийн зардалд зарцуулжээ.

### **Б.3 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.**

Б.3.1. Аймаг, сумын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар тухайн сонгуулийн хорооны зардлын дансанд гарын үсэг зурж, хуваарилагдсан зардлыг СЕХ-ноос ирүүлсэн зүйл ангийн дагуу Төрийн сан дахь дансаар дамжуулан зарцуулсан байна.

СЕХ-ноос Хэнтий аймагт орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох зааврын дагуу ирүүлснийг аймгийн Сонгуулийн хороо 3 удаагийн санхүүжилтээр тодорхой тайлбарын хамт сумын сонгуулийн хороодод хүргүүлсэн байна. Мөн нэмэлт сонгуулийн зардлыг Дэлгэрхаан, Өмнөдэлгэр сумдад хуваарилан хүргүүлжээ.

СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 3.4-т<sup>1</sup> заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо нь сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд хангалттай хяналт тавьж чадаагүй байна. Тухайлбал:

Автоматжуулсан системийн эрчим хүчний эх үүсвэрийг бэлтгэх зардлаас 8 сумын Сонгуулийн хороо 1701.8 мянган төгрөгөөр 40 мотор түрээслэж, 3 сумын Сонгуулийн хороо уг зардлыг зарцуулаагүй байна.

*Баянмөнх, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Биндэр, Норовлин, Мөрөн, Хэрлэн, Бор-Өндөр сумд 40 мотор түрээсэлсэн бол Баянхутаг, Дархан, Дэлгэрхаан сумд уг зардлыг зарцуулаагүй.*

Аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 33 дугаар бичгийн 2 дугаар хавсралт, 6 дугаар зүйлд<sup>2</sup> нөөц эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх талаар зөвлөмж өгөгдсөн боловч эрчим хүчний найдвартай эх үүсвэргүй, цахилгаан тасрах үед ашиглах нөөц эх үүсвэрт шаардлагатай шатахууныг ямар зардлаас гаргахыг тодорхой зааж өгөөгүйгээс 6 сумын Сонгуулийн хороо 1145.6 мянган төгрөгийг шатахуун бэлтгэхэд зарцуулсан байна.

Б.3.2. Хэнтий аймгийн УБХ нь аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгуулийг зохион байгуулахад 1600.0 мянган төгрөгийн шатахууны талоныг "Магнай трейд" ХХК-аас худалдан авч зарцуулсныг жолоочийн тооцооны хуудаастай

<sup>1</sup> 3.4 "... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина."

<sup>2</sup> "Эрчим хүчний эх үүсвэрийг бэлтгэх зардлыг санал авах байрыг гэрэлтүүлэх, эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай болон цахилгаан тасарсан үед ашиглах мотор түрээслэх зориулалтаар шаардлагатай хэсэгт 50.0 мянган төгрөгөөр тооцон зарцуулах



тулган шалгахад дараах алдаа, дутагдал ажиглагдаж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгааг нотлож байна. Үүнд:

1. Сонгогчийн нэрийн жагсаалтыг Бэрх, Батноров, Баян-Овоо, Норовлин, Дадал, Баян-Адрага сумдад хүргэсэн байтал өөр багийн Баян-Адрага суманд давхар ажиллан зардал хэмнэх боломжийг ашиглаагүй.

2. Батлагдсан сонгогчдийн нэрсийн жагсаалтыг хүргэхэд олгосон 200.0 мянган төгрөг, УБХ-ээс сумдад сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэл хүргэхэд олгосон 100.0 мянган төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудас байхгүй, явсан зам маршрут тодорхойгүй байна.

3. Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгсэлд доголдоход гарах зардлыг тооцоогүйгээс санал авах өдөр Дархан суманд ажилласан шуурхай багийн шатахуунд нэмэлт зардал гарсан.

Олгосон шатахууныг спидометрийн заалт, явсан километр, шатахуун зарцуулалтын нормтой тулган тооцохгүйгээр тооцоо бодож байгаа дутагдал нийтлэг байсныг зориуд цохон тэмдэглэж байна.

Хэрэв сонгогчдын жагсаалт хэвлэх зардал, шатахууны зардалд тавих хяналтыг зохих ёсоор тавьж, арвилан хэмнэж чадсан бол аймгийн УБХ-т нэмэгдэл 1680.0 мянган төгрөгийг нэмж зарцуулахгүйгээр зардлын үр өгөөжийг сайжруулах боломж байжээ.

Хэнтий аймагт 2020 оны орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгуулийг зохион байгуулахад Батширээт, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Баянхутаг сумын сонгуулийн хороод зардлын хэмнэлтийг хэмнэлт чигээр нь үлдээн тайлагнасан бол зарим сумд сонгуулийн бүх зардлыг дуустал зарцуулсан нь зардлыг хэмнэх боломжтой байсныг мөн харуулж байна.

Иймд цаашид Сонгуулийн зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

**Холбогдох байгууллагын санал:**

  
**ХЭНТИЙ АЙМАГ  
СОНГУУЛИЙН ХОРОО**  
23119 Чингис хот, Хэнтий аймаг,  
Утас (976)-7056-2401

2020.11.25 № 58  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлтэй холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ДАРГА  Ж. ГАНБААТАР



**Саналд өгсөн тайлбар:**

Аймгийн Сонгуулийн хороо тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад Хэнтий аймгийн Сонгуулийн хороонд улсын төсвөөс нийт 475.3 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 470,4 сая төгрөг буюу 98,9 хувийг зарцуулж, 4,9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.
- Аймгийн Сонгуулийн хороо хуваарилагдсан төсвийг холбогдох журмыг баримтлан аймаг, сумын сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөжээ.
- Аймаг, сумдын Сонгуулийн хороо батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арилан хэмнэлттэй зарцуулсан байна.
- Зарим сумдын Сонгуулийн хороо сонгуулийн зардлыг зөвлөмжийн дагуу зарцуулж тайлагнаагүй байна.
- Аймгийн Сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны сонгуулийн төсвийн зарцуулалтад тавих хяналт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Аймгийн Сонгуулийн хорооны дарга Ж.Ганбаатар-т:**

- Сумдын Сонгуулийн хороонд хуваарилсан төсвийг үнэн зөв тайлагнаж байх,
- Аймгийн Сонгуулийн хороо нь сумын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад тавих хяналт тавих хяналтыг сайжруулах,

### **ҮАГ-т:**

- ОБЕГазраас /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ОБГазарт олгосон ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгсэл нь хэдэн төгрөгний үнэ бүхий бараа материал ирсэн нь тодорхойгүй байгаад анхаарах.

## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 дугаар сарын 30

Дугаар А/30

Чингис хот

#### Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан “Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол улсын Ерөнхий аудиторов 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн удирдамжаар хийгдэж буй “Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардал”-д хийсэн Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн сонгуулийн хороонд тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР